



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар A/86

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ны 2 дахь хэсэг 2.4.3.1, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 7 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг тус гэрээний дагуу түр хязгаарлах арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН



Х.АЛТАЙ

Гүйцэтгэх захирлын 2017 оны 05 дугаар сарын 11-ний
өдрийн 1/8 тоот тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга
хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниудын нэрс**

1. "Аргай Бэст ҮЦК" ХХК
2. "Блүмсбюри секюритис ҮЦК" ХХК
3. "Масдак ҮЦК" ХХК
4. "Монсек ҮЦК" ХК
5. "Нэйшнл Секюритис ҮЦК" ХХК
6. "Өндөрхаан ҮЦК" ХХК
7. "Сикап ҮЦК" ХХК

---oOo---